



ГАЗАР ЗОХИОН БАЙГУУЛАЛТ,  
ГЕОДЕЗИ ЗУРАГ ЗҮЙН ГАЗРЫН  
ДАРГЫН ТУШААЛ

2022 оны 05 сарын 31 өдөр

Дугаар А/117

Улаанбаатар хот


Орон тооны бус мэргэжлийн зөвлөлийн  
дарга, орлогч дарга, нарийн бичгийн  
даргыг батлах тухай

Засгийн газрын агентлагийн эрх зүйн байдлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.4 дэх хэсэг, Барилга, хот байгуулалтын Сайдын 2016 оны 160 дугаар тушаалаар баталсан “Архитектор, инженерийн орон тооны бус мэргэжлийн зөвлөлийн ажиллах журам”-ын 4.5 дахь хэсгийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Газар зохион байгуулалтын орон тооны бус мэргэжлийн зөвлөлийн даргаар Монгол Улсын их сургуулийн Шинжлэх ухааны сургуулийн Газарзүйн тэнхимийн багш, доктор, дэд профессор Г.Гантулгыг, орлогч даргаар Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн газрын Захиргаа, удирдлага, хамтын ажиллагааны газрын дарга Р.Ганхуягийг, нарийн бичгийн даргаар Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн газрын Газар зохион байгуулалтын хэлтсийн ахлах мэргэжилтэн Ц.Ихбаярыг тус тус баталсугай.

2. “Геодези, зураг зүй, Инженер хайгуул, мониторинг, Газар зохион байгуулалт, Орон зайн мэдээллийн технологийн орон тооны бус мэргэжлийн зөвлөлийн ажиллах журам”-ыг үйл ажиллагаандаа мөрдөж ажиллахыг Газар зохион байгуулалтын орон тооны бус мэргэжлийн зөвлөл /Г.Гантулга/-д даалгасугай.

ДАРГА



А.ЭНХМАНЛАЙ

1522010603